



Оюу Толгой ХХК

Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон байгаль орчны
Удирдлагын тогтолцооны журам

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

1. ЗОРИЛГО

Энэхүү журам нь дуу чимээнээс үүдэн байгаль орчин болон орон нутагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилготой. Мөн журамд орчны дуу чимээг хянахад ашиглах зөөврийн дуу чимээний түвшин хэмжигч багаж ашиглах зааварчилгаа багтсан. Дуу чимээг эх үүсвэр болон хүлээн авах мэдрэг цэгүүд дээр хэмжих шаардлагатай ба ингэснээр үйл ажиллагаанаас үүсэх дуу чимээг үндэсний стандартууд болон ердийн дууны түвшинтэй харьцуулах боломжтой болно. Хэрэв дуу чимээний түвшин үндэсний стандартын шаардлагаас давсан нь тогтоогдвол засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч дууны түвшинг зохих түвшинд хүргэнэ.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү журам нь Оюу Толгой компанийн Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон Байгаль орчны мониторингийн хөтөлбөрт тусгагдсан хүлээн авах мэдрэг цэгүүд дэхь дуу чимээний түвшингийн мониторинг хийх үйл ажиллагааг хамарна.

3. АЛБАН ТУШААЛ, ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Албан тушаал	Үүрэг хариуцлага
ЭМААБО-ны ерөнхий менежер	<ul style="list-style-type: none">Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлагын туслалцаа болон нөөц бололцоог бүрдүүлэхЖурмыг баталж, Оюу Толгой компанийн бүх ажилтан, гэрээт ажилтнуудад хүргэх
Байгаль орчны менежер	<ul style="list-style-type: none">Дуу чимээг хянах үйл ажиллагаанд байгаль орчны мэргэжилтний зүгээс туслалцаа үзүүлэх, үндсэн болон гэрээт ажилтнуудад дуу чимээний удирдлагын талаар зөвлөгөө өгөх
Байгаль орчны ахлах ажилтан	<ul style="list-style-type: none">Дуу чимээ болон түүний удирдлагыг хянах болон холбогдох зөвлөгөөг байгаль орчны мэргэжилтний зүгээс өгөхЭнэхүү журмын хэрэгжилтийг хянах. Хэрэв журмын шаардлагууд хангагдаагүй бол шалтгааныг тодорхойлох зорилгоор хэлтсийн менежерүүдтэй уулзаж, шаардлагатай бол сануулах буюу арга хэмжээ авах
Хэлтсийн менежер	<ul style="list-style-type: none">Хэлтсийн ажилтнуудаа шаардлагатай дуу чимээний сургалтанд хамруулах
Талбайн ахлах ажилтан / Ахлах мэргэжилтнүүд	<ul style="list-style-type: none">Ажлын талбайгаар үзлэг шалгалт явуулж, дуу чимээ бүхий ажлууд энэхүү журмын хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавих (ж.нь., шөнийн цагаар дуу чимээ ихтэй барилгын ажил хийгддэггүй байх)
Бүх үндсэн болон гэрээт ажилтнууд	<ul style="list-style-type: none">Хэт их дуу чимээ бүхий аливаа үйл ажиллагааны талаар Ахлах ажилтандаа мэдэгдэх
Сургалтын хэлтэс	<ul style="list-style-type: none">Зөвшөөрөгдөх стандартаас давсан дуу чимээ гаргах боломжтой ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтнуудад зориулсан сургалтын шаардлагыг тодорхойлох
Бүсийн хөгжил, нийгмийн харилцаа	<ul style="list-style-type: none">Холбогдох дуу чимээний мониторингтой холбоотой мэдээллийг орон нутгийн иргэдэд хүргэхДуу чимээний мониторингтой холбоотой орон нутгийн иргэдийн санал хүсэлтийг зохицуулах

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

4. ЖУРАМ

Дуу чимээний мониторингийг эх үүсвэр дээр (дуу чимээ гарч буй цэгүүдэд), болон хүлээн авах мэдрэг цэгүүд дээр (ж.нь., өвөлжөө, булаг шанд, хэвтэр, үүр зэрэг зэрлэг ан амьтны нутаглах газар) хийнэ.

4.1. Дуу чимээг бууруулах (Ерөнхий)

а) Дуу чимээ ихтэй барилгын үйл ажиллагааг өдрийн ажлын цагаар (07.00-22.00) төлөвлөж явуулах, тэр дундаа Оюу Толгой компанийг төлөөлөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй дуу чимээ ихтэй хөдөлгөөнт эх үүсвэрүүдэд онцгой анхаарал хандуулж өдрийн цагаар явуулах;

б) Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн тодорхойлолтод заасны дагуу ажиллуулахад тохиромжтой нөхцөлд байлгах ба ашиглаагүй үед унтраасан байна;

в) Боломжтой бөгөөд эрсдлийн үнэлгээгээр шаардлагатай гэж тогтоосон нөхцөлд хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн дуу чимээг багасгах зорилгоор дараах инженерийн хяналтын арга хэмжээг авна:

- Яндангийн чимээ намсгагчийг үйлдвэрлэгчээс заасан тодорхойлолтод нийцүүлж ашиглах;
- Хөдөлгүүрийн яндан, компрессорын бүрдлүүдэд тохирох чимээ намсгагчийг суурилуулах;
- Давтамжит дуу чимээ гаргаж буй төхөөрөмжид дуу шингээгч хаалт хийх;
- Сэнсний дуу намсгагч;
- Дуу чимээ гаргагч төхөөрөмжид хаалт хийх буюу холдуулах
- Механик тоног төхөөрөмжид чичиргээний тусгаарлалт хийх;

г) Боломжтой бол чанга дуу чимээ бүхий тоног төхөөрөмжид (генератор, бутлагч, тээрэм, компрессор, насос, хурдны хайрцаг зэрэг) дууны хаалт, дуу намсгагч, дуу тусгаарлагч, болон хашилт хийнэ;

д) Боломжтой бол дуу чимээ багатай төхөөрөмжийг сонгож ашиглах буюу худалдаж авах;

е) Ирж буй дуу чимээг бууруулах боломжтой бол тоног төхөөрөмж болон хүлээн авах цэгийн хоорондох зайг аль болох хол байлгах.

ё) Хүдэр боловсруулах үйлдвэрт дуу чимээний хяналт явуулж, өдрийн турш дуу чимээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрэхгүй түвшинд байгаа эсэхийг хянаж шалгах, баталгаажуулах;

ж) Мэдрэг хүлээн авагчийн ойролцоо төслийн стандартаас давсан хэмжээний дуу чимээ үүсгэх боломжтой уул уурхайн үйл ажиллагаа явуулах бол ойр орчмын оршин суугчдад мэдэгдэх

з) Дуу чимээ ихтэй үйл ажиллагааг эхлүүлэхийн өмнө (мэдрэг хүлээн авах цэгүүдэд төслийн стандартад заасан түвшнээс хэтрэх дуу чимээ гаргах боломжтой буюу магадлалтай) ажлын явц, ажиллах хөтөлбөр, тооцоолж буй дууны түвшин болон тоног төхөөрөмж, машины үйлдвэрлэгчийн тодорхойлогчийг багтаасан ЭМААБО-ны төлөвлөгөөг гэрээт байгууллагаас Оюу Толгой компанид өгч батлуулна.

4.2. Хэмжилт хийх бэлтгэл

а) Талбайн хэмжилт хийхээс өмнө дараах алхмуудыг гүйцэтгэнэ:

- Шөнийн хэмжилт хийх тухайгаа Байгаль орчны ахлах ажилтанд дор хаяж 2 хоногийн өмнө мэдэгдэх ба ингэснээр шаардлагатай бол өдрийн ажлын хуваарийг өөрчилж, шөнийн хэмжилтэд зориулан амрах боломжийг бүрдүүлнэ;

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

- Талбайн ажилд зориулсан Дуу чимээний түвшний бөглөх хуудас авах – бөглөх хуудас дотоод сүлжээнд MS Excel болон PDF форматаар хадгалагдана.
- Хэмжилт хийх журам болон хэмжилтийн төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах талаар дэлгэрэнгүй заавар харах зорилгоор дуу чимээний хэмжилт хийх АСЖ-г бэлдэж авч явна.

4.3. Хэмжилтийн ерөнхий зааварчилгаа

Дуу чимээний түвшин хэмжих АСЖ-аас:

- а) Дуу чимээний мониторинг хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж;
- б) Тоног төхөөрөмжийн бэлтгэл, баталгаажуулалт, тохируулга;
- в) Дуу чимээний мониторинг хийх төхөөрөмжийг хэрхэн ажиллуулах (2238 Mediator чимээ хэмжигч);
- г) Зөөврийн цаг уурын аппарат (Kestrel 4500)-ыг хэрхэн ашиглах, ямар мэдээллийг тэмдэглэх;
- д) Мониторинг хийхэд шаардлагатай сургалт болон
- е) Хэмжилтийн талбай дахь хугацаа, хоорондын зай болон хэмжих үзүүлэлтүүдтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллүүдийг авна уу.

Энэхүү баримт бичгийн Хавсралт 1-д дуу чимээний мониторинг хийх үеэр бөглөх шаардлагатай хуудсын жишээг, Хавсралт 2-д дуу чимээ хэмжих байршлуудын уртраг өргөргийг харуулсан. Хавсралт 3-д тэдгээр байршлуудыг газрын зураг дээр үзүүлнэ. Дуу чимээг хэмжих цэгүүдийг дараах шалтгаануудыг харгалзан сонгосон:

- Оюу Толгой компаний дуу чимээ ихтэй үйл ажиллагаанаас мэдрэг хүлээн авагч орчинд үзүүлэх нөлөөг хэмжих
- Ердийн дуу чимээний түвшинг хэмжиж, Оюу Толгойгоос гарч буй дуу чимээтэй харьцуулах боломжийг бүрдүүлэх.

4.4. Тоо мэдээлэл болон баримт

- а) Хэмжилтийн талбайгаас ирээд Байгаль орчны мониторингийн ажилтан хэмжилтийн тоо мэдээлэл, баримтыг Дуу чимээний түвшин хэмжих АСЖ-д заасны дагуу хадгална.

4.5. Үр дүнг мэдээлэх

- а) Байгаль орчны ахлах ажилтан хэмжилтийн үр дүнг үндэсний стандартын шаардлагуудтай харьцуулна. Хэрэв дуу чимээний түвшин үндэсний стандартаас шаардлагаас давсан байвал энэ тухай мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллагад улирал тутам мэдээлж байна;
- б) Хэрэв хуулийн шаардлагаас давсан буюу хэвийн бус байдал ажиглагдсан тохиолдолд Байгаль орчны ажилтан Байгаль орчны ахлах ажилтанд мэдэгдэж, шалгуулна. Шаардлагатай бол Байгаль орчны ахлах ажилтан хэтэрсэн тохиолдлыг шалгах зорилгоор ахин хэмжилт хийж болно;
- в) Хэрэв ахин хэмжилтээр дуу чимээний түвшин хэтэрсэн нь тогтоогдвол тухайн чанга дуу чимээг гаргаж буй хэлтэс/гэрээт байгууллагад яаралтай мэдэгдэж, засч залруулах арга хэмжээг шуурхай авна;
- г) Дуу чимээний мониторингийн хэмжилтийн үр дүнг улирлын болон жилийн байгаль орчинд тайланд оруулах ба тэдгээр нь эрх бүхий төрийн байгууллагад хүргэгдэнэ.

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

5. ТОДОРХОЙЛОЛТ

ОТ – Оюу Толгой ХХК

АСЖ – Ажлын Стандарт Журам

Дуу чимээний чичиргээ – Дуу чимээний агаарт үүсгэж буй давтамжийн чичиргээ, хүний биед очиж буй хүрээлэн буй орчин дахь нам давтамжаар дамжих

6. ЛАВЛАХ МАТЕРИАЛ

6.1. Холбогдох Монгол улсын стандарт

Дуу чимээ болон чичиргээнд хамаарах Монгол улсын байгаль орчны чанарын стандартууд:

- MNS 4585:2007 *Монгол улсын агаарын чанарын стандарт* – гадаад орчны дуу чимээний хүлцэх хэмжээ.
- MNS 17.5.1.21:1992 *Автомтээврийн хэрэгслийн дуу чимээ. Дуу чимээний хүлцэх түвшин хэмжих арга*
- Засгийн газрын 2006 оны 149-р тогтоолын 2-р хавсралт, *Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм* – ОТ уурхайн талбайд тэсэлгээний ажил явуулахдаа энэхүү стандартад нийцүүлэн ажиллах шаардлагатай.

6.2. Холбогдох зээлдэгчийн стандарт, зааварчилгаа

ОТ компани нь Олон Улсын Санхүүгийн Корпораци болон Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкнаас гаргасан стандартуудыг хэрэгжүүлэн ажиллана. Үүнд:

- ОУСК-ийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандарт (2006) (ялангуяа ГЦ1: *Нийгмийн болон байгаль орчны үнэлгээ ба Удирдлагын тогтолцоо*, мөн ГЦ3 *Бохирдлоос сэргийлэх, бууруулах*);
- ОУСК *Байгаль орчин, Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагааны ерөнхий зааварчилгаа* (2007 оны 4-р сар);
- ЕСБХБ Гүйцэтгэлийн шаардлага (2008) (тэр дундаа ГШ1: *Байгаль орчин, нийгмийн үнэлгээ, удирдлага*);
- *Е6 – Дуу чимээ, чичиргээний хяналт* (2008 оны 12-р сар), энэхүү зааварчилгаанд дуу чимээ, чичиргээний хязгаарлалт байхгүй. Уг баримт бичигтэй хавсран Рио Тинтогийн Гар ажиллагаа болон чичиргээний БЗ стандартыг (2008 оны 12-р сар) ашиглах ба ажлын байран дахь дуу чимээ, чичиргээний өртөлтийг тусгаж өгсөн байдаг;
- *Рио Тинто Дуу чимээ, чичиргээний хяналтын зааварчилгаа*
- *Рио Тинто Ажлын байран дахь эрүүл мэндийн стандартууд.*

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

7. БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ

Баримт бичгийн нэр	ОТ-10-Е6-PRC-0001-М-Дуу чимээний мониторинг ба хяналтын журам
Тайлбар	Байгаль орчны журам
Эх Зохиогчид	Марк Ньюби
Боловсруулсан огноо	2013.04.25
Баталсан	Марк Ньюби, Байгаль орчны менежер
Баталсан огноо	2013.05.26
Өөрчлөлтийн бүртгэлийн дугаар	##

Эрсдлийн зэрэглэл	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийн үнэлгээ хийсэн	Хянан засварлах давтамж	Дараагийн хяналт хийх огноо
Дундаж	2013.05.06	Б.Долгор	2 жил тутам	2015.05.06

Хувилбар	Хувилбарын огноо	Зохиогч (ид)	Баталсан	Хяналт засварын тухай тайлбар
1.0	2013.05.06	Марк Ньюби	Марк Ньюби, Байгаль орчны менежер	Баримт бичгийг баталсан.

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

Хавсралт 2. Дуу чимээний түвшний мониторинг хийх цэгүүдийн байршил

№	Цэгийн нэр	UTM	X	Y	Хэмжүүр	Давтамж
1	NMP-AP01	48 T	651425	4772837	Дуу чимээний түвшин (дБ)	Сар бүр
2	NMP-AP02	48 T	649881	4775572		
3	NMP-AP03	48 T	651473	4778257		
4	NMP-AP04	48 T	653061	4775529		
5	NMP-AP05	48 T	648697	4775587		
6	NMP-AP06	48 T	654121	4775521		
7	NMP-LA01	48 T	651363	4769668		Улирал тутам (2, 3, 8, 11-р сарын эхний 10 хоногт)
8	NMP-LA02	48 T	658038	4764168		
9	NMP-LA03	48 T	653732	4756733		
10	NMP-LA04	48 T	644802	4763987		
11	NMP-LA05	48 T	659894	4751623		
12	NMP-LA06	48 T	666314	4765565		
13	NMP-LA07	48 T	650786	4777811		
14	NMP-LA08	48 T	635498	4773418		
15	NMP-LA09	48 T	635960	4755321		
16	NMP-LA10	48 T	647811	4749515		
17	NMP-LA11	48 T	687332	4803854		
18	NMP-PA01	48 T	654770	4775427		Сар бүр
19	NMP-PA02	48 T	648237	4777345		
20	NMP-PA03	48 T	648251	4781459		
21	NMP-PA04	48 T	651505	4779197		
22	NMP-PA05	48 T	647285	4776895		
23	NMP-PA06	48 T	652471	4779686		

Дуу чимээний мониторинг болон хяналтын журам		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.05.06	Баримт бичгийн дугаар: ОТ-10-Е6-PRC-0001-М	Хувилбар: 1.0

Хавсралт 3. Дуу чимээний мониторинг хийх цэгүүдийн байршлын зураг

